

Баримт бичгийн нэр	“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
Гүйцэтгэгч	“Саусгоби сэндс” ХХК
Төслийн нэр	Овоот Толгой нүүрсний уурхай (MV-012726)
Огноо	2025/03/21
Төлөвлөгөө боловсруулсан	Б.Мөнх-Очир /Химийн бодис, хог хаягдал хариуцсан мэргэжилтэн/ Д.Дөлгөөн /Газар хариуцсан мэргэжилтэн/ Б.Цулбаяр /Усны мэргэжилтэн/ Б.Төрбагана /Нөхөн сэргээлт Орон нутаг хариуцсан мэргэжилтэн/ Ж.Цэрэндулам /БООНХ ахлах мэргэжилтэн/
Хянасан	Д.Ариунболд /Байгаль орчин, орон нутгийн харилцааны хэлтсийн менежер/
Баталсан	Шюй Жинь Шөн /Саусгоби сэндс ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал
Хүлээн авагч хуулийн этгээд	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Өмнөговь аймгийн Байгаль орчны газар
Хувийг	Өмнөговь аймгийн Гурвантэс сумын ЗДТГ

ГАРЧИГ

ГАРЧИГ.....	2
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Төслийн товч мэдээлэл	4
2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
2.1. Байгаль орчны төлөв байдал	6
2.1.1. Физик газарзүйн онцлог.....	6
2.1.2. Цаг уур, уур амьсгал	7
2.1.3. Гадаргын болон газар доорх усан сүлжээ	7
2.1.5. Хөрсөн бүрхэвч.....	7
2.1.6. Ургамлын аймаг	7
2.1.7. Амьтны аймаг	7
2.2. Төслийн нийгэм-эдийн засгийн төлөв байдал	8
2.2.1. Овоот Толгой төслийн байршил.....	8
2.2.2. Хүний нөөц.....	8
2.2.3. Дагалдах дэд бүтэц.....	9
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	19
3.1. Ил уурхайн нүүрс олборлох үеийн болзошгүй нөлөөлөл.....	20
3.2. Хуримтлагдах нөлөөлөл	22
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	23
4.1. Эрх зүйн үндэслэл	24
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	27
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	27
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	29
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	29
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	30
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	31
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	33
13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	34
14. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	35

ГРАФИК

График 1. Хүний нөөцийн бүрэлдэхүүн	8
---	---

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Төслийн ерөнхий мэдээлэл	5
Хүснэгт 2. Төслийн талбайн байгууламжууд.....	9
Хүснэгт 3. Уурхайд ажиллах үндсэн тоног төхөөрөмж	16
Хүснэгт 4. Овоот Толгой уурхайн нөхөн сэргээлтийн мэдээлэл.....	17

Хүснэгт 5. Ил уурхайн үйл ажиллагааны үед байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь (БОННУ тайлангаас 2023 он).....	18
Хүснэгт 6. Төслийн үйл ажиллагаа болон бүс нутагт хэрэгжиж буй бусад төслүүдээс үүсэлтэй болзошгүй хуримтлагдах нөлөөлөл	20
Хүснэгт 7. Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн ангилал	27
Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах ажил.....	29
Хүснэгт 9.Нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах зардлын задаргаа	31
Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалахаар санал болгож буй газар	32
Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах ажлын зардал	33
Хүснэгт 12. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	34
Хүснэгт 13. Соёлын өвийг хамгаалах хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө.....	34
Хүснэгт 16. Овоот Толгой уурхайн хог хаягдлын ангилан ялгалт.....	41
Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын задаргаа	42

ЗУРАГ


Зураг 1. Овоот Толгой уурхайн байршил.....	4	
Зураг 2. Овоот Толгой уурхайн Нармандах малталтын хэсэг	5	
Зураг 3. Лицензийн талбайн байршил	8	
Зураг 4. Уурхайн ажилчдын тосгон.....	10	
Зураг 5. Засварын газар	11	
Зураг 6. Шатахуун түгээх станц болон агуулах	11	
Зураг 7. Дэд бүтцийн байгууламж Тэсрэх бодисын агуулах	12	
Зураг 8. Гаалийн баталгаат агуулах (а. Наржаргах уурхай б. Нармандах уурхай).....	12	
Зураг 9. Овоот Аэродром	13	
Зураг 10. Нарийнсухайт-шивээхүрэн чиглэийн хүнд даацын концессын авто зам	14	
Зураг 11. Бохир ус цэвэршүүлэх байгууламж	14	
Зураг 12. Нүүрсийг нойтон технологиор баяжуулах үйлдвэр	15	
Зураг 13. Хогийн цэг (кемп, засвар).....	17	
Зураг 14. МТ 4400 хүнд даацын машин	Зураг 15. PV275 Тэсэлгээний өрөм, Экскаватор	18
Зураг 16. Овоот Толгой уурхайн объектийн нөлөөлөл	Error! Bookmark not defined.	
Зураг 17. Дүйцүүлэн хамгаалахаар санал болгож буй газар нутаг		28

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч мэдээлэл

Овоот Толгой нүүрсний уурхайд ашиглалт явуулж буй Саусгоби сэндс ХХК нь (улсын бүртгэлийн дугаар: 9019019096) Канад улсад төвтэй, Торонто болон Хонг-Конгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Саусгоби Ресурс Лимитед (TSX.V: SGQ, HK: 1878) нээлттэй хувьцаат компанийн Монгол дахь салбар бөгөөд Монгол улсад нүүрсний хайгуул, олборлолтоор дагнан 18 дахь жилдээ ажиллаж байна.

Овоот Толгой уурхай нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэр V буюу Бага овоо багийн нутагт, Хөвхийн хөндий–Нарийн сухайтын нүүрсний орд газарт, Даланзадгад хотоос 320 км, нийслэл Улаанбаатар хотоос 950 км зайд, баруун өмнөд зүгт, Шивээ-Хүрэнгийн боомтоос 56 км-т (х.ө 42°59'619, з.у 101°16'83, өндөршил д.т.д 1526 метр) оршдог. Тусгай зөвшөөрлийн дугаар MV-012726 (9312.27 га) ба 2039.09.20-ны өдрийг дуустал тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа үйлчилж байна.



Зураг 1. Овоот Толгой уурхайн байршил

Тус компанийн олборлолт явуулж буй “Овоот Толгой” уурхайгаас хагас коксжих, дунд болон өндөр үнслэгт нүүрс олборлож байна.

Саусгоби сэндс ХХК нь Овоот Толгой нүүрсний орд газрын хайгуулын ажлаа 2005 онд эхэлж, 2007 оны 9-р сард ашиглалтын лиценз авсан бөгөөд 2008 оны 9-р сард анх нүүрс экспортолж эхэлсэн. Тус уурхай нь Баруун уурхай буюу “Наржаргах – Sunset”, Зүүн өмнөд уурхай буюу “Нармандах – Sunrise” гэсэн 2 малталтын хэсэгт ашиглалт явуулж байна. Овоот толгой уурхайгаас дараах 3 төрлийн нүүрсийг олборлож байна. Үүнд:

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

- Хагас коксжих нүүрс / Үнслэг 0-10%/
- Дунд зэргийн үнслэгтэй хагас коксжих нүүрс / Үнслэг 10-15%/
- Эрчим хүчний нүүрс / Үнслэг >15%/



Зураг 2. Овоот Толгой уурхайн Нармандах малталтын хэсэг

Нүүрсийг Шивээхүрэнгийн боомтоор БНХАУ руу экспортлох бөгөөд гол хэрэглэгч нь Хятадын Төмөрлөгийн үйлдвэрүүд юм. Уурхайн хүчин чадал нэмэгдүүлэхтэй холбогдон “Техник-эдийн засгийн үндэслэл”-ийг 2021 онд шинэчлэн боловсруулж байгаа ба нарийвчилсан хайгуулаар 345.8 сая тонн (А+В+С) нүүрсний нөөц илрүүлснээс уурхайн хил хязгаар дотор үйлдвэрлэлийн нөөц 142.8 сая.тн, үүнээс 2008-аас 2024 оны 12 сарын 01-ний байдлаар 52.18 сая.тн нүүрс олборлосон ба үлдэх 90.6 сая.тн нөөцийг жилийн 7.0 сая тонн хүчин чадлаар 13 жил ашиглах юм.

Овоот толгой нүүрсний уурхай төслийн ерөнхий мэдээллийг Хүснэгт-1-т үзүүлэв.

Хүснэгт 1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	Саусгоби сэндс ХХК
Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9019019096 (Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар)
Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Гадаад худалдаа, Ашигтмалтын хайгуул хийх, Ашигт малтмалын ашиглалт
Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, стадион оргил махатма ганди, 22, Моннис Бьюлдинг 8-р давхар
Захиралын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Шюй Жинь Шөн; 976-70070710; 3334 jinsheng.xu@southgobi.com
Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Д.Ариунболд; 976-70070710; 3414 Ariunbold.Dogmisangi@southgobi.com

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ Дугаар Хүчинтэй хугацаа	Ашигт малтмал ашиглах (нүүрс) MV-012726 2039.09.20 дуустал
Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ Дугаар Хүчинтэй хугацаа	Химийн бодис ашиглах № 9019019096 Хүлээгдэж байгаа
Галын дүгнэлт	Нийт 7 обект дээр галын дүгнэлттэй 1. ШТС 2. Ажилчдын хотхон 3. Засварын цех, 4. Нисэх онгоцны буудал 5. Гаалийн үйлчилгээ-1/нармандах уурхай/ 6. Гаалийн үйлчилгээ-2/наржаргах уурхай/ 7. Нүүрс угаах үйлдвэр
Химийн бодисын агуулгад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт	Нэгдсэн агуулах дотор химийн бодис хадгалах тусгай төмөр шүүгээ бүхий хэсэгтэй. Агуулахыг 2013 онд улсын комисст хүлээлгэж өгсөн ба мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй.
Орон нутагтай газар эзэмшлийн тухай хийсэн гэрээний огноо, баталсан хуулийн этгээдийн нэр, албан тушаал, байгууллага	Дугаар: Нийт 31 газар газар ашиглах хүчинтэй гэрчилгээтэй
Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	Нэмэлт тодотголын ерөнхий үнэлгээ баталсан огноо: 2012.09.05 өдөр БОНХЯ /хуучнаар/ баталсан.
Байгаль орчний нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотгол тайлан. Баталсан хуулийн этгээд БОАЖЯ	БОННУ-ний нэмэлт тодотголын тайлан 2023 оны 12 дугаар сарын 08-нд батлагдсан.
Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	Ус ашиглах дүгнэлт БОМТ-гөө батлагдсаны дараагаар Усны газраар гаргуулна.
Төслийн нэр	Овоот Толгой нүүрсний уурхай
Төслийн харьяаллын байршил	Бага-Овоо баг, Гурвантэс сум, Өмнөговь аймаг
Төслийн ангилал	Нүүрсний олборлолт
Төсөл эхэлсэн огноо	2008 он
Төсөл хэрэгжих хугацаа	2039 он хүртэл
ТЭЗҮ баталсан огноо	2022 он (ТЭЗҮ шинэчилсэн)
2024 оны бүтээгдэхүүний хэмжээ /дундаж/ 12 сарын 31-ний өдрийн байдлаар	Хуулсан хөрс: 53,98 сая м ³ Олборлосон нүүрс: 8.8 сая тонн Экспортолсон нүүрс: 6,7 сая тонн

2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Байгаль орчны төлөв байдал

2.1.1. Физик газарзүйн онцлог

Овоот Толгой уурхай орших Нарийн Сухайтын нүүрсний сав газар нь физик газарзүйн мужлалтын хувьд Алтайн уулархаг их мужийн Говь-Алтайн мужид хамаарна. Хойд талаараа Бумбын нуруу (2360 м), Тостын нуруу (2517 м), Тахилгын хяр (2316 м) гэсэн 30 км өргөнтэйгөөр 180 км үргэлжлэх уулсаар хүрээлэгдсэн, уулнаасаа эх аван газрын гадаргуугаа дагасан урагш чиглэсэн хэдэн арван км үргэлжлэх хуурай сайруудаар ихээхэн хэрчигдсэн газар юм. Тус сумын нутаг дэвсгэрт Алтайн нурууны үргэлжлэл болох хэд хэдэн эгнээ нам уулт өндөрлөг, тэдгээрийн хоорондох өргөн уудам хоолой хөндийн хэсэг хамаарагдана. Ордын дүүргийн харьцангуй өндөр 1525-1545 м.

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

2.1.2. Цаг уур, уур амьсгал

Эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөл -15-20⁰С хүйтэрч, зун +30 -35⁰С заримдаа +40⁰С хүрч халдаг. Жилдээ дунджаар 98-102 мм орчим тунадас унадаг. Хур тунадасны бараг 90-95% нь дулаан улиралд буюу 7 8 дугаар саруудад орох бөгөөд хүйтний улиралд тун бага тунадас унадаг. Өвөл 0-3 мм, зун 30-60 мм, жилд 100 мм- ээс бага тунадас унана.

2.1.3. Гадаргын болон газар доорх усан сүлжээ

Төслийн талбай болон түүний орчмоор Хацавч, Дов, Хэлтгий малгайт, Товхон, Хөөвөр, Хөх Толгой, Нарийн Сухайт, Жигдэн зэрэг хуурай сайрууд дайран өнгөрнө. Чулуулаг массивын доторхи сайрууд, өгөршлийн бүсэд газар доорх ус нь гар худгуудын үр дүнгээр тогтоогдсон ба ундарга нь гол төлөв 0.1 л/с буюу ерөнхийдөө тэнд уулын чулуулгийн ан цавын ус агууламж

бага байна. Ордын хэмжээнд үүссэн тектоник хагарал-тохойрлын гүний усны орчимд эрдэсжилт бага, харьцангуй цэнгэг (0.8 г/л) устай, тохойрлоос холдох тутам тухайлбал Зүүн хэсэгт нь усны эрдэсжилт 4.5 г/л сульфатлаг-хлорт натрийн найрлагатай нь ажиглагддаг байна.

Тус бүс нутаг түр зуурын урсацтай бүсэд хамаарна. Зөвхөн эрчимшил ихтэй хур борооны үед бага зэргийн гадаргын урсац хуурай сайруудаар үүсэж зарим хотгор хонхор газрыг дүүргэх нөхцөлтэй.

2.1.5. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбайн хойд хэсгээр орших нам уулсаар уулын хээржүү цөлийн цайвар бор хөрс тархаж байхад Хүрэн овоо, Зангад Толгой зэрэг алсын бараа харах өндөрлөгүүдтэй хуурай сайраар хэрчигдсэн аараг толгодоор сул хөгжилтэй чулуурхаг бор саарал хөрстэй. Хуурай сайр ихтэй Ховхийн хөндий нэртэй хэвгий талархаг газраар цөлийн гөлтгөнөт бор саарал хөрс нийтлэг тархана.

2.1.6. Ургамлын аймаг

Овоот Толгой уурхайн лицензийн талбай байрлах газар нутаг нь Өмнөговь аймгийн Гурвантэс сум, манай орны ургамалшлын бүс бүслүүрийн хувьд Цөлийн бүс, Ургамал-Газарзүйн мужлалаар Говь-Алтайн цөлөрхөг хээрийн, баруун хэсэг Алтайн Өвөр говийн, өмнөд хэсэг Алашаа говийн тойрогт хамаарна. Монгол орын ургамал газарзүйн мужлалаар тус тойрог нь бусад тойргуудаас зүйлийн бүрдлээр хамгийн ядмаг газар.

Цөлөрхөг хээрийн бүс нь Монголын хээр, Төв Азийн цөлийн зааг дээр нилээд эрт үүсэж бий болсон, зөвхөн энэ бүсэд ургадаг зонхилгогч ургамлуудтай байдгаараа онцлогтой. Цөлөрхөг хээрийн бүсэд жилдээ ихэвчлэн 100-125 мм хур тундас унана. Ургамал ургах хугацаа 170-190 хоног үргэлжлэх боловч байнга гандуу юмуу гантай, хүчтэй салхи, шороон шуургатай байдаг нь ургамлын амьдралд муугаар нөлөөлдөг.

2.1.7. Амьтны аймаг


Овоот Толгой нүүрсний уурхай орших Нарийн сухайтын сав газар нь Монгол орны амьтны аймгийн мужлалаар Говь Алтай уулын тойрог, Алашаа говийн цөлийн тойрогт багтдаг. Иймд төслийн талбайн хойд бие үргэлжилсэн цавчим өндөр хадархаг уулсаар хүрээлэгдсэн бол талбайн урд хэсэг нам, хайргархаг бэсрэг толгод, тэгш талархаг гадаргуутай, талбайн хүрээнд байнгын урсацтай булаг, шанд уст цэгүүд олон тул амьтны зүйлийн тооны хувьд харьцангуй баялаг газар юм.

Уурхайн лицензийн талбай түүний ойр орчмоор 2005 оноос хойш хийсэн БОННУ тайлан, түүний нэмэлт тодотголууд, мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлсэн судалгаанаас харахад нийт 22 зүйлийн хөхтөн, 86 зүйл нүүдлийн болон суурин шувуу, 13 зүйлийн мөлхөгчид, хоёр нутагтан, 380 зүйлийн сээр нуруугүйтэн бүртгэгдсэн байна.

2.2. Төслийн нийгэм-эдийн засгийн төлөв байдал

2.2.1. Овоот Толгой төслийн байршил

Овоот Толгой уурхай (12725А тусгай зөвшөөрөл бүхий 9308 га талбай) нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэр V баг буюу Бага овоо багийн нутагт, Хөвхийн хөндий–Нарийн сухайтын нүүрсний орд газарт, Даланзадгад хотоос 320 км, нийслэл Улаанбаатар хотоос 950 км зайд, баруун өмнөд зүгт, Шивээхүрэнгийн боомтоос 56 км-т (х.ө 42'59"619, з.у 101'16"83, өндөршил д.т.д 1526 метр) оршдог.



Зураг 3. Лицензийн талбайн байршил

2.2.2. Хүний нөөц

Саусгоби сэнс компани нь ажиллах хүчин, хүний нөөцийн бүрдүүлэлтийг хийхдээ орон нутгаас ур чадвар, шаардлага хангасан иргэдэд давуу байдал олгох, мэргэжлийн эрхтэй боловч ур чадвар туршлага тутмаг боловсон хүчнийг сургаж улмаар мэргэжил олгох, нэмэлт ур чадвар олгох замаар



мэргэшүүлж дадлагажуулж ажиллууладаг. Бид зөвхөн өөрийн боловсон хүчнийг сургаж бэлтгээд зогсохгүй орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэжлийн боловсон хүчинг бэлгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Их дээд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг санхүүжүүлэн хэрэгжүүлдэг. Саусгоби сэнд компанид 2024 оны 12-р сарын 25-ны байдлаар нийт 675 хүн ажиллаж байгаагаас Овоот Толгой уурхайд 613 хүн ажиллаж байна. Үүнээс Гурвантэс сум-117, Ноён сум-8, Сэврэй сум-31, Даланзадгад-83, УБ хот болон бусад аймгаас-374 тус тус байна.

График 1. Хүний нөөцийн бүрэлдэхүүн

2.2.3. Дагалдах дэд бүтэц

Уурхай байрлах тус бүс нутагт “МАК” ХХК, “Хүрэн толгой коал майнинг” ХХК, “Магнай Трейд” ХХК, “Вагнер Азия” ХХК, “Бласт” ХХК, “Өсөх зоос” ХХК зэрэг олон аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байгаа тул зам, дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн. Овоот Толгой уурхайн хувьд MV-012726 тусгай зөвшөөрлийн 9312,27 га талбайн 2040,49 га талбайд уурхайн эдэлбэр болон бусад барилга байгууламжуудыг барьж байгуулан газрыг зохих зөвшөөрлийн дагуу ашиглаж байна. Үүнд ажилчдын хотхон, уурхайн захиргааны цогцолбор, механик цех, материал хангамж, хадгалалт хариуцсан агуулах, тогтмол нислэг бүхий нисэх буудал, шатахуун түгээх станц, нүүрсний чанарын лаборатори, нүүрс угаах үйлдвэр болон бусад байгууламжууд орно.

Хүснэгт 2. Төслийн талбайн байгууламжууд

№	Газрын байршил	Зөвшөөрөлтэй газрын хэмжээ, га
	Уурхайн ажилчдын тосгон	10
	Хүнд машин механизм засварын газар	34.2
	Тэсэлгээний агуулах	4
	Аммиак эмульсийн үйлдвэр	4
	Нүүрсний агуулах склад	19.1
	ШТС-ын агуулах	7.5
	Нүүрс баяжуулах үйлдвэр /хуурай/	98.94
	Гаалийн хяналтын талбай	31.79
	Нүүрс угаах үйлдвэр	32.4
	Нүүрс баяжуулах үйлдвэрийн хаягдлын талбай	17.47
	Нүүрс баяжуулах үйлдвэрийн хаягдлын овоолго	54.14
	Наржаргах уурхай	181.47
	Нармандах уурхай	188.11
	Наржаргах уурхайн овоолго	568.21
	Нармандах уурхайн овоолго	475.78
	Нармандах уурхайн өргөтгөл	39.14
	Шимт хөрсний овоолго	35.33
	Нисэх онгоцны буудал	133.7
	Цэвэрлэх байгууламж	0.3
	Үерийн уснаас хамгаалах далан	1.09
	Хаягдал усны талбай	1.4
	Бохирдсон хөрсний талбай	0.8
	Үйлдвэрийн усан сан	0.5
	Цахилгаан дамжуулах шугам	60.15
	Цахилгаан дамжуулах шугам	1.9
	Цахилгаан дамжуулах шугам	5.3
	Цахилгаан дамжуулах шугам	1.4
	Ус дамжуулах хоолой	6.07
	Шимт хөрсний овоолго	4.26
	Нөхөн сэргээлтийн талбай	16.44
	Ажилчдын тосгон	5.6
	Нийт	31 газар, 2040.49 га

2.2.3.1. Ажилчдын тосгон

Овоот Толгой уурхай нь 2009 онд 292 хүний багтаамжтай ажилчдын тосгон бариулж ашиглалт оруулж мөн 2011 онд 312 хүн амьдрах боломжтой үйлчилгээ, конторын өргөтгөл бүхий шинэ барилга “ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

ашиглалтанд оруулснаар нэг ээлжиндээ нийт 608 орчим хүн хүлээж авах хүчин чадалтай тосгон болж өргөжсөн. 2024 онд кемпийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 350 хүн байрлах өргөтгөл барилгын ажил хийгдэж байна. Үүнд:

- Уурхайн тосгон нь ажилчдын амьдрахад өрөөнүүд 1-4 ортой, 1 ортой, 2 ортой, VIP өрөө бүхий зохион байгуулалттай.
- Ажилчдын амралт чөлөөт цагт зориулж теннис, бялдаржуулах өрөө, бильяардын, ТВ өрөөг, спорт цогцолбортой.
- Өндөр хүчин чадалтай бүрэн автомат угаалгын машин, хатаалгын машин болон цагаан хэрэглэл индүүддэг зориулалтын машин зэрэг иж бүрэн тоног төхөөрөмжтэй угаалгын цех ажилладаг.
- Гал тогоо нэг ээлжиндээ 350 хүн зэрэг хооллох хүчин чадалтай, сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон. Нарийн боов, зуух, мах, ногоо бэлтгэлийн өрөө тус тусдаа ба эрүүл ахуйн стандартын шаардлага бүрэн хангагдсан.
- Ажилчдын ээлж сольдог Ниссан автобус, 45 хүний суудалтай Daewoo автобус 3 автобустай. Уул, Баяжуулах, Засварын хэлтсүүдийн ажилчдыг өглөө, оройн ээлжээр сольдог ба Гурвантэс сумын ажилчдыг хувиарт ээлжээр зөөж байна.



Зураг 4. Уурхайн ажилчдын тосгон

2.2.3.2. Засварын газар

Засварын хэлтэс нь уурхайн хүнд машин механизм, тоног төхөөрөмж, техникийн засвар үйлчилгээ, бэлэн байдлыг хангаж ажилладаг ба тоног төхөөрөмжүүдийн ажилласан мот/цагаас хамааруулж урсгал засвар болон их засварын ажлуудыг тогтмол гүйцэтгэдэг.

Засвар үйлчилгээний төв нь 24 цагийн тасралтгүй ажиллагаатай бөгөөд дараахь цех тасгуудаас бүрддэг. Үүнд:

1. Гагнуурын хэсэг.
2. Дугуй засварын хэсэг.
3. Урсгал засварын хэсэг
4. Угаалгын хэсэг
5. Хувцас угаалгын хэсэг
6. Гар болон жижиг оврын багажны өрөө
7. Хувцас солих өрөө
8. Албан тасалгаанууд
9. 60 хүний хооллох танхим
10. 30 хүний сургалтын танхим
11. 30 хүний хурлын заал

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

12. 30 хүний гэрээт болон өөрийн ажилчдын контор
13. 5 хэсэг бүхий МТ4400 засварлах засварын хэсэг



Зураг 5. Засварын газар, хангамжийн агуулах

Мөн хангамжийн хэлтэс нь материал татан авалт хадгалалтыг өргөтгөх зорилгоор нэмэлт өргөтгөл барьж холбогдох газруудад хүлээлгэн өгсөн.

2.2.3.3. Шатахуун түгээх станц

Манай компани уурайн хэрэгцээг хангах зорилгоор 2008 онд “Гурван зам” ХХК-ны барьж байгуулсан Шатахуун Түгээх Станцыг 2011 онд худалдан авсан ба өөрийн шатахууны дотоод хэрэгцээг тус ШТС-аас хангаж байна. Тус ШТС нь нийт 1300 м³ багтаамжтай бөгөөд түүний 80%-д шатахуун цэнэглэж дунджаар 1040 м³ шатахууны нөөцтэй ажилладаг. Шатахуун хүлээн авах, хадгалах, ачиж түгээх хүчин чадлыг нэмэгдүүлэх ажил хийгдэж байна.



Зураг 6. Шатахуун түгээх станц болон агуулах

2.2.3.4. Цахилгаан хангамж

Уурхайн тосгон, Засварын төв, ШТС, Нисэх буудал 6кВ-н цахилгаан дамжуулах агаарын шугамаар, Нүүрс угаах үйлдвэр 35кВ-н ЦДАШ-аар тус тус төвийн цахилгаан хангамжинд холбогдсон ба бэлтгэл тэжээлд Уурхайн тосгон Atlas Copco Q1X165 400 кВт хүчин чадалтайг, нисэх буудлын цахилгаан хангамжинд Olympian GELH30 21.6кВт хүчин чадалтай, засварын газарт Plamac GSW170D 400кВт хүчин чадалтай дизель цахилгаан үүсгүүрүүдийг ххэрэглэдэг.

Уурхайн гэрэлтүүлэг: Уурхайн шөнийн ээлжинд уулын ажил явагдаж байгаа хэсгүүд болон овоолгын ахилтын хэсгүүд дээр “Ingersoll Rand”-ийн 10 ширхэг хөдөлгөөнт дизель гэрэлтүүлгийг ашигладаг. Нүүрсний агуулах болон тэсрэх материалын агуулахууд нь генератороор тэжээгддэг суурин шонгууд бүхий гэрэлтүүлэгтэй.

2.2.3.5. Дулааны сүлжээний усыг халаах нам даралтын зуух

Овоот Толгой уурхайд ажиллагсдын тосгонд байрлах 1-CLSG-308 2-CLSG-240 3-CLSG-60, засварын төвд байрлах 1-CLSG-90 2-CLSG-20 3-CLSG180, Нүүрс угаах үйлдвэрт DZL-2400 маркын дулааны

сүлжээний усыг халаах нам даралтын ус халаалтын зориулалт бүхий зуухнуудтай. Тус зуухны засвар үйлчилгээг 2013 оны 10 сард “Терма калор” ХХК-иар хийж гүйцэтгүүлсэн



Зураг 7. Дэд бүтцийн байгууламж Тэсрэх бодисын агуулах

2.2.3.5. Гаалийн баталгаат агуулах, Пүүний хэсэг

Нүүрсний шинэ агуулах 2009 онд байгуулсан ба 800.000 тонн нүүрс агуулах хүчин чадалтайгаар ашиглалтанд оруулсан. 2010 онд уг агуулахыг гаалийн баталгаат нүүрсний агуулах болгон баталгаажуулсан. Нар мандах уурхайн гаалийн баталгаат агуулахыг 2013 онд барьж ашиглалтанд оруулсан.

Өдөрт 12 цаг ажиллах боломжтой, 250тн-ын 4ш автопүүтээр дунджаар 266 ш нүүрс тээврийн машиныг пүүлж 39900тн нүүрс экспортлох хүчин чадалтай.



Зураг 8. Гаалийн баталгаат агуулах (а. Наржаргах уурхай б. Нармандах уурхай)

2.2.3.6. Нисэх онгоцны буудал

Саусгоби сэндс ХХК Овоотын хилийн цэргийн анги ашиглаж байсан онгоцны буудлыг сайжруулан ашиглаж байна. Овоот нисэх буудал нь сумын төвөөс зүүн урд зүгт 38 километр, уурхайн шинэ кемпээс зүүн зүгт ойролцоогоор 10 км газарт, тусгай зөвшөөрөлтэй талбай дотроо N 43°00'46", E 101°20'00" солбилцолд байрладаг бөгөөд Саусгоби сэндс ХХК-ийн өөрийн нисэх буудал юм.



Зураг 9. Овоот Аэродром

Овоот нисэх буудал нь хоёр давхар сэндвичэн хавтан барилга, нисэх зурвасын 1,95 км урт хатуу хучилттай зам бүхий нисэхийн цаг уурын бодит ажиглалтын Вайсала (Vaisala) систем, агаар газар болон газар, газрын холбооны суурин станц 2, нөөц станц тус тус 2 ширхэгийг суурилуулсан ба ИНЕГ-ын холбогдох алба салбараас гэрчилгээжүүлэн ашигладаг. Мөн онгоцны газрын цахилгаан тэжээл үүсгүүр, аюулгүй байдлын үзлэгийн бүрэн тоног төхөөрөмжтэй. Овоот нисэх буудал нь их засварын улмаас нислэг үйлдэгдэхгүй байгаа болно.

2.2.3.7. Зам тээвэр

Өмнөговь аймгаас Гурвантэс сум хүртэлх нийт 1672 км орон нутгийн зам, Даланзадгад-Гашуун сухайтын хилийн боомт-улсын хил хүртэл Даланзадгадаас Цогт-Овоо сумаар дамжин Дундговь аймгийн хил хүртэлх улсын чанартай замтай байна. Улсын дундаж сайжруулсан замын уртыг Өмнөговь аймагтай харьцуулахад улсын дунджаас 5.9 дахин доогуур замтай байна. Гурвантэс сум орчмын дэд бүтцийн байдал нь харьцангуй сайн хөгжсөн. Сумын төвөөс Овоот Толгой уурхайн талбай руу 34 км сайжруулсан шороон замаар явж очно. Сайжруулсан шороон замыг Саусгоби сэнс ХХК компани Орон нутгийн захиргааны хүсэлтийн дагуу барьж байгуулсан болно. Тус уурхайгаас Хятадын хил хүртлэх нүүрс тээвэрлэх шороон замтай бөгөөд 2010 онд Нарийн сухайтаас Шивээ-Хүрэн хүртэл 45 км хатуу

хучилттай замыг Чинхуа-МАК-Нарийн Сухайт ХХК өөрийн хөрөнгөөр байгуулсан. 2010 онд Саусгоби сэнс ХХК мөн нүүрс тээврийн хүнд даацын 45км зам байгуулах төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2014 оны 9 сар тус төслийг хэрэгжүүлж дууссан.

2.2.3.8. Нарийнсухайт-шивээхүрэн чиглэлийн хүнд даацын концессын авто зам

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 198 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад орсон Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн авто зам барих концесс олгох уралдаант шалгаруулалтанд "Эн Ти Би" ХХК болон "Саусгоби сэнс" ХХК нарын түншлэл оролцож шалгарсан.

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

Энэхүү төслийг хэрэгжүүлэх зорилгоор тус компаниудын хамтран байгуулсан "Ар Ди Си Си" ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 262 дугаар тогтоолын дагуу 2011 оны 10-р сарын 26-ны өдөр Төрийн Өмчийн Хороотой "Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто замын Барих-Ашиглах-Шилжүүлэх" концессын гэрээний хүрээнд арван таван жилийн ашиглалтын дараа төслийн замыг улсын мэдэлд үнэ төлбөргүй шилжүүлэн өгөх байгуулсан.

Шинэ замын барилгын ажлын нийт өртөг 109 орчим тэрбум төгрөг бөгөөд уурхайн тээврийн хүнд даацын машин явахад зориулагдсан (нэг тэнхлэгийн даац 26 тн), 25 см цементээр бэхжүүлсэн суурь, 24 см цементбетон хучилттай Монголд анх удаа баригдсан зам юм.

Шивээхүрэн боомтоор экспорт хийж байгаа баруун сумдын нүүрс тээврийн бүх машинууд байгаль орчныг хамгаалах, улмаар орон нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах үндсэн нөхцлийг бүрдүүлэн, орчны бохирдлыг бууруулах чухал ач холбогдолтой чанартай замаар зорчиж тээвэр хийх нөхцөл бүрдсэн.




Зураг 10. Нарийнсухайт-шивээхүрэн чиглэлийн хүнд даацын концессын авто зам

2.2.3.9. Бохир ус цэвэршүүлэх байгууламж

Уурхайн тосгон болон засварын газар дахь бохир ус цэвэршүүлэх байгууламжийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг Хятадын “Beijing Longanhuacheng Architectural Designing” Co.,Ltd-ийн хийсэн ажлын зургийн дагуу тус компани хийж гүйцэтгэсэн. Цэвэрлэх байгууламж нь механик, биологи, химийн аргуудаар бохир усыг цэвэрлэх ба төслийн хүчин чадлыг 132 м³ гэж төслийн тайлбар бичигт дурьдсан байдаг.

Одоогоор хоногт дунджаар 60-80 м³ бохир усыг хүлээж авч байна. Бид тус онд уурхайн цэвэрлэх байгууламжуудын технологийн горимыг сайжруулах, цэвэрлэгдэн гарч буй усыг стандартын төвшинд 100% нийцүүлэх зорилгоор Үндэсний зөвлөх Вестминистр ХХК-ийн Монгол улсын зөвлөх инженер Ц. Цацрал ахлагчтай багийг авч ажиллуулан бодит үр дүнд хүрч ажилласан. Мөн 2014 онд сантехникийн ажлыг гүйцэтгэж саарал усаа мод ногоон байгууламж услах байдлаар дахин ашиглаж байна.



Зураг 11. Бохир ус цэвэршүүлэх байгууламж

2.2.3.10. Нүүрсийг нойтон технологиор баяжуулах үйлдвэр

“Саусгоби сэндс” ХХК нь нүүрсний зах зээлийн нөхцөл байдал болон цахилгааны эх үүсвэр зэрэг хүчин зүйлээс шалтгаалж ил уурхайгаас олборлож буй нүүрсийг чанараар /үнслэг, бөсөх индекс/ нь 3 ангилан, нүүрсний агуулахад хураан зөөврийн шигших төхөөрөмжийг ашиглаж ангилалт хийн борлуулсаар ирсэн. Цаашид бохирдол анхдагч нүүрсийг нойтон буюу гравитацийн аргаар баяжуулж борлуулах нь эдийн засгийн хувьд ашигтай бөгөөд туршилт судалгааны ажил дээр үндэслэн баяжуулах үйлдвэрийн төслийн ажлыг гүйцэтгэн НБҮ-г байгуулан ажиллаж байна.

“Саусгоби Сэндс” ХХК нь Овоот толгойн ордын Нармандах, Наржаргах хэсгийг түшиглэн жилд 1.5 сая.тонн нүүрсийг нойтон технологиор баяжуулах үйлдвэрийг ашиглах бөгөөд эхний жилүүдэд тэжээлийн түүхий нүүрснийхээ дийлэнхийг Наржаргах хэсгээс, үлдсэн тодорхой хувийг Нармандах хэсгээс хангана. НБҮ нь Овоот Толгойн ордын ил уурхайн WF ангилалын нүүрсийг гравитацийн аргаар баяжуулна.



Зураг 12. Нүүрсийг нойтон технологиор баяжуулах үйлдвэр

Нүүрсийг нойтон аргаар баяжуулах үйлдвэр нь Овоот Толгойн ордын ил уурхайн Наржаргах уурхайгаас олборлосон бохирдолтой нүүрс буюу WF ангиллын /үнслэг 25%-иас дээш/ нүүрсийг баяжуулж 6000-6500 кКал илчлэгтэй WB ангиллын /угаасан баяжмал/ бүтээгдэхүүн гарган авах чиглэлээр ажилласан. НБҮ-ийлдвэрийг ажиллуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, сэлбэг татан авалт, эргэлтийн усны танкнуудын цэвэрлэгээ, тэжээлийн нүүрсний татан авалт, хаягдал тээвэрлэлт, ажиллах хүн хүчний бүрдүүлэлт, сургалтыг хийж ажилласан. Хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөө, компанийн нүүрс боловсруулалтын бодлогын дагуу Нүүрс нойтон технологиор баяжуулах үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжүүдийг солих шинэчлэлийн ажил 2024 оны 2-р сарын 28-ний өдрөөс эхлэн хийгдэж эхэлсэн ба 2024 оны 6-р сарын 19-ний өдөр их засвар, шинэчлэлтийн ажлыг дуусгаж үйлдвэрийг залгасан.

Баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалтын хувьд 41.5% үнслэгтэй анхдагч нүүрсийг гравитацийн аргаар боловсруулж баяжмалын гарц 50-60%-тай байна. Овоот Толгойн нүүрсийг үнслэгээр нь дараах байдлаар ангилж байна. Үүнд:

- ▶ А нүүрс буюу үнслэгийн хэмжээ <10.5%
- ▶ В нүүрс буюу үнслэгийн хэмжээ 10.5-17,5%
- ▶ F нүүрс буюу үнслэгийн хэмжээ 25%< дээш

2.2.3.11. Нүүрс баяжуулах хэлтсийн засварын хэсэг, Лаборатори

2024 оны I улиралд НБҮ-ийн дэргэд Засварын хэсгийн барилгыг угсран, бага оврын засварын төхөөрөмжүүд, токарийн универсал машин, гидро шахагч, суухин тасдагч, өрөм, гагнуурын төхөөрөмжүүд зэргийг суурилуулж металл боловсруулалт хийх, үйлдвэрийн тоноглолуудад засвар

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

хийх, зарим сэлбэг материал хадгалах, засварын болон хангамжийн агуулах, үйлдвэрийн ажилчид, засварчдын амрах өрөөтэй байхаар төлөвлөн ашиглалтад оруулсан.

Үйлдвэрлэлийн өдөр тутмын чанарын хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор НБҮ-ийн дэргэд MNS ISO 17025-2018 стандартаар итгэмжлэгдсэн лабораторийн үйл ажиллагаа 24 цагаар явагдаж байна. Лабораторийн үйл ажиллагааг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2024 онд бүх тоног төхөөрөмжийг шинэчлэн суурилуулсан ба нүүрсний техникийн шинжилгээг (чийг, үнслэг, хүхэр, илчлэг, дэгдэмхий) НБҮ, ХБҮ, шигшүүр зэрэгт гүйцэтгэж ажилласан. Мөн 2024 оны 6-р сараас эхлэн Ж-индексийн шинжилгээ, баяжуулах туршилт зэргийг хийж байна.



Зураг 13. Баяжуулах үйлдвэрийн засварын хэсэг, Лаборатори

2.2.3.12. Нүүрсийг хуурай технологиор баяжуулах үйлдвэр

Нүүрсийг хуурай технологиор баяжуулах анхны үйлдвэр нь 2011 онд 3 багц FGX-48A болон эргэлтэт өөрөөр бутлагч бутлуураас бүрдэх иж бүрэн тоног төхөөрөмж худалдан авч, 2012 оны 3-р сард төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Тухайн үеийн нүүрсний зах зээлийн нөхцөл байдал болон нүүрсний үнэ зэргээс хамааран төслийн 1-р шат буюу нүүрс бэлтгэн ангилах хэсгийг ашиглалтад оруулсан. 2023 онд тухайн үйлдвэрийг дахин ашиглахаар төлөвлөн жилийн 2.3 сая тонн нүүрс боловсруулах хүчин чадалтайгаар ТЭЗҮ-г боловсруулж батлуулсан.



Зураг 13. Хуурай баяжуулах үйлдвэр

2.2.3.13. Хог хаягдлын цэг

Уурхайн хог, хаягдлын менежментийн үр ашигтай байдал, тогтвортой хэрэгжилтийг хангах нь уурхайн байгаль орчны ажилчдын болон нийт байгаль орчны хэлтсийн голлох үүргийн нэг юм. Уурхайн талбай дээрх хог, хаягдлын менежментийн үр ашигтай хэрэгжүүлэхэд чиглэсэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

- Уурхайн хэмжээнд хог, хаягдлын эх үүсвэрүүдийг тодорхойлох,
- Уурхайн хог, хаягдлын хэмжээг бууруулахад чиглэсэн журам боловсруулах,
- Хог хаягдалтай холбоотой сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх,
- Үр ашигтай тээвэрлэлт, устгал, дахин ашиглалын горимыг хэвшүүлэх,
- Бүртгэл, тайлангын систем бий болгох, мэдээллийн сан үүсгэх,
- Хог хаягдлын менежментийн үүрэг хариуцлагын механизмыг бүрдүүлэх гэх мэт



Зураг 14. Хогийн цэг (кемп, засвар)

Уурхайн хог, хаягдлын менежментийн хэрэгжилтийг тусгай зөвшөөрөл бүхий, орон нутгийн компани болох “Хайртын босго” ХХК гардан гүйцэтгэх ба байгаль орчны мэргэжилтэн явцын хяналтыг өдөр бүр хийдэг. Гэрээт гүйцэтгэгч нь дараах ажлыг гүйцэтгэдэг. Үүнд:

- Уурхайн хэмжээнд тогтоогдсон бүх хог хаягдлын эх үүсвэрүүдээс тээвэрлэлт хийж зөвшөөрөгдсөн хогын цэгт буулгах,
- Эх үүсвэр дээрх ангилан ялгалтыг хянах, мэдээллэх,
- Хогийн цэгийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулах,
- Дахин ашиглах эсвэл дахин боловсруулах хаягдлыг ангилах, хувиарлахад туслах,
- Устгах, булшлах хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах, боловсруулах хаягдлын хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн менежментийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх,
- Хортой болон аюултай хог хаягдлын хадгалалт, хамгаалалтыг хариуцах
- Хог хаягдлын өдөр тутмын бүртгэлийг хөтлөх, тайлан гаргах

2.2.3.14. Төсөлд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн жагсаалт

Саусгоби сэнс ХХК –ийн олборлолт явуулж буй “Овоот Толгой” ил уурхай нь хагас коксжих, дунд болон өндөр үнслэгт нүүрс олборлож байна. Уурхай нь 2008 онд анх олборлолтоо эхлүүлсэн ба “Нармандах” болон “Наржаргах” уурхайн амуудаас (карьер) нүүрс олборлож байна. Уурхайн хүчин чадал нэмэгдүүлэхтэй холбогдон “Техник-эдийн засгийн үндэслэл”-ийг 2015 онд шинэчлэн боловсруулж, батлуулсан ба нарийвчилсан хайгуулаар 345.8 сая тонн (А+В+С) нүүрсний нөөц илрүүлснээс уурхайн хил хязгаар дотор үйлдвэрлэлийн нөөц 142.8 сая.тн, үүнээс 2008-с 2024 оны 12 сарын 01-ний байдлаар 52.18 сая.тн нүүрс олборлосон ба үлдэх 90.6 сая.тн нөөцийг жилийн 7.0 сая тонн хүчин чадлаар 13 жил ашиглах юм.



Зураг 14. Наржаргах уурхайд олборлолт явуулж буй байдал


Ордын уул геологийн нөхцлөөс хамааруулан уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг экскаватор, автосамосвалын хослолоор гүйцэтгэх ашиглалтын системийг сонгосон. Хөрсийг гадаад болон дотоод овоолгод, нүүрсийг баяжуулах үйлдвэр хүртэл, баяжмалыг төмөр замын дэргэдэх агуулах хүртэл, хаягдлыг хөрсний гадаад овоолгод тус тус тээвэрлэнэ. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалтыг Хүснэгт 3–д үзүүлэв.

Хүснэгт 3. Уурхайд ажиллах үндсэн тоног төхөөрөмж

№	Техникийн төрөл	Тоо
1	Экскаватор	8
2	Хүнд даацын автомашин	33
3	Дугуйт ачигч	5
4	Түрэгч	6
5	Дугуйт түрэгч	3
6	Грейдер	3
7	Өрөм	9
8	Бутлуур	4
9	Дунд оврын автомашин	21
10	Суудлын машин	49
11	Бусад тоног төхөөрөмж	110
	Нийт	251



Зураг 15. MT 4400 хүнд даацын машин, грейдер



Зураг 16. PV275 Тэсэлгээний өрөм, Экскаватор

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Овоот Толгой уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг нарийвчлан тогтоох зорилгоор “Майк Грийн” ХХК-ийн судлаачид 2022 оны 7-8 саруудад төслийн талбайд хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Овоот Толгой уурхайн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг “Майк Грийн” ХХК 2023 онд боловсруулан БОАЖЯ-аар батлуулсан.

БОННУ тайлангийн нэмэлт тодотголын ажлыг гүйцэтгэхдээ Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шинжилгээ хийх журам”, БОАЖЯ-ны шинжээчийн гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тавьсан шаардлага зэргийг үндэс болгосон ба байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх талаар Дэлхийн банк болон НҮБ-ын Ази, Номхон далайн нийгэм, эдийн засгийн комиссоос гаргасан арга зүй зэргийг баримталсан болно.

Манай компани ордыг ашиглаж эхэлсэн 2008 оноос эхлэн олборлолтын ажил эрчимтэй тасралтгүй явагдсан ирсэн ба ордын хэмжээнд нийт 52,18 сая.тн нүүрс олборлож, 212.86 сая.м³ хөрс хуулж, одоогийн байдлаар 2040.49 га газар уурхай болон уурхайн холбогдох объектуудаар ашиглалтад өртөж байгалийн ландшафтын оронд үүсмэл ландшафт бүрдэх, газрын нөөц багасах, газрын гадаргын хэв шинжид өөрчлөлт бий болгосон байна.

Овоот Толгой нүүрсний уурхайн байгаль орчны нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа 2009 оноос эхлэсэн бөгөөд сүүлийн 14 жилийн хугацаанд нийт 149.86 га талбайд техникийн, 48.98 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж орон нутаг, улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

Хүснэгт 4. Овоот Толгой уурхайн нөхөн сэргээлтийн мэдээлэл

Нөхөн сэргээлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023-2024
Биологийн нөхөн сэргээлт (га)	15.6	10.6	14.2	1.6	2	-	1.68	1	1	1.3	-	-	-	-
Техникийн нөхөн сэргээлт (га)	18.6	16.2	17.2	1.6	2	25.3	1.68	1	1	1.3	-	15	-	-
Нийт нөхөн сэргээсэн талбай (га)														149.86

Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний мэргэжлийн байгууллага болох “Майк Грийн” ХХК Овоот Толгой уурхайн Болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг дараах байдлаар нэгтгэн урьдчилан тогтоолоо. Үүнд:

- Төслийн талбай орчимд хуулиар хамгаалагдсан газар нутаг, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байхгүй байна. Харин төслийн үйл ажиллагааны үр дүнд газар нутгийн эмзэг байдлаас шалтгаалж сөрөг нөлөө үүсэх, үүссэн сөрөг нөлөө хуримтлагдаж болзошгүй нөхцлүүд байх боломжтой байна.
- Тус төслийг ил аргаар олборлоход газрын хэвлий 260 м хүртэл гүнд эвдрэлд орж, уурхай, дэд бүтцийн барилга байгууламж, зам талбай зэрэгт 1,778.1 га талбайн гадарга, хөрс, ургамалан нөмрөг нөлөөлөлд өртөхөөр байна.
- Уурхайн ашиглалтын хугацаанд талбайн геологийн тогтоц, үржил шимт хөрс хуулагдаж, ургамлын нөмрөгийн бүрэн бүтэн байдал, органик нэгдлийн хуримтлал сарнин устаж, хөрс ургамлын үе давхаргад тархан төлжиж амьдарч байсан бичил организм, шавьж хорхой, сээр нуруугүйтэн болон бусад амьтдын амьдрах орчин өөрчлөгдөж, амьдралын хэвийн тогтолцоо тодорхой хэмжээгээр алдагдана.

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

- Газрын гүний усан орчны нөөцөд сөргөөр нөлөөлнө.
- Үйл ажиллагааны явцад нилээд хэмжээний тоос шороо босч ил гарсан гадаргуугаас салхиар зөөгдөн ойр хавийн ялангуяа салхины давамгайлах чиглэлийн дагуу хөрс ургамлыг дарж байгалийн өнгө төрхийг муутгах, ойролцоох айлууд, ургамал, амьтны хэвийн амьдрах нөхцөлийг алдагдуулна.

Саусгоби сэнс ХХК нь БОННУ-ний үнэлгээгээр тогтоогдсон эдгээр гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзсэн тэдгээр сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хариу арга хэмжээ авч ажиллаж байна.

3.1. Ил уурхайн нүүрс олборлох үеийн болзошгүй нөлөөлөл

Овоот Толгойн уурхайгаас нүүрс олборлох уурхайн технологи ажиллагаа, түүнийг хаах үеийн Леопольдын матрицыг дараах хүснэгтээр үзүүлж уурхайн технологийн үе шат бүр байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх эрчмийн байдлыг үзүүлэв. Ийнхүү Леопольдын матрицын аргаар дүгнэж үзэхэд ил уурхай технологийн үе шатуудаас хөрс хуулалт, тэсэлгээ, өрөмдлөг, нүүрс тээвэрлэлт, овоолго үүсгэх, нүүрс угаах зэрэг үйл ажиллагаа нь тухайн орчиндоо нөлөөлөл үзүүлнэ.

Хүснэгт 5. Ил уурхайн үйл ажиллагааны үед байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь (БОННУ тайлангаас 2023 он)

Байгаль орчны үзүүлэлтүүд	Шууд	Шууд бус	өрөө	Богино	Урт хугацаанд	Буцаж	Буцалтгүй	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн экосистемийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт	х				х		х			х
Гадаргын усны урсацын өөрчлөлт	х				х		х	х		
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х		х		х	
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х		х		х	
Геологийн тогтоцын өөрчлөлт	х				х		х	х		
Зэрлэг амьтдын орон зай		х			х		х			х
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		х			х		х			х
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын доорх нөөц баялаг	х				х		х		х	
Бэлчээрийн байдал	х				х		х			х
Эрдэс түүхий эдийн нөөц	х				х		х		х	
Эрчим хүчний нөөц	х				х		х			х
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт	х	+			х		х			х
Гадаргын усны чанарын өөрчлөлт	х			х					х	
Агаарын бохирдол	х				х		х			х
Хөрсний бохирдол	х				х		х			х
Хорт бодис усаар дамжин хүн ам, ан амьтанд нөлөөлөх		х		х		х			х	
Дуу чимээ, шуугианы нөлөө	х				х	х			х	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	х				х		х		х	

Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x	x		
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх										
5.Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x				x		x	x		
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x	x		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x		x	
Ажлын байр нэмэгдэх	x				x		x		x	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x			x
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	x				x		x			x
6.Бусад нөлөөлөл										
Ашиглалтын үед шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	x				x		x			x
Байгалийн урсгал болон хур тунадасны усаар дамжин усны химийн найрлага өөрчлөгдөх, хүчиллэг урсац бий болох	x			x		x			x	
Уурхайн хананы тогтвортой байдал алдагдаж гулсалт нуруулт үүсэх	x			x		x				x
Хүчтэй салхи, түймэр, газар хөдлөл, аянга		x		x		x				x
Дүн	25	4	-	5	24	4	24	5	11	13

Тус уурхайн үйл ажиллагаанаас үүдэн гарч болох болзошгүй нөлөөлөл 29 байна. Эдгээр болзошгүй нөлөөллийн чиглэл, үргэлжлэх хугацаа, эрчим тус бүр нь байгаль орчин, нийгэм эдийн засагт хэрхэн үйлчлэхийг авч үзсэн дээрхи хүснэгтээс дараах дүгнэлт гарч байна.

Шууд нөлөөлөл: Энд нийт нөлөөллийн ихэнх буюу 25 нөлөөлөл хамрагдаж нийгэм-эдийн засагтай холбоотой 4 нь эерэг, бусад нь сөрөг нөлөөлөл байна. Үүнд: ил уурхайн хөрс хуулалт, тэсэлгээ хийх, нүүрс ачих, сул чулуулаг болон хаягдлын овоолго хийх зэрэг үйл ажиллагаанаас шууд шалтгаалж газрын тогтоц өөрчлөгдөх, хөрс эвдэрч элэгдэх болон бохирдох, усны чанар ба урсацад өөрчлөлт орох, орчны тоосжилт нэмэгдэх, уурхайн машин механизмын дуу чимээ тасралтгүй гарах, ландшафтын өнгө, хэлбэр болон байгалийн төрх өөрчлөгдөх, болзошгүй ослын үед гарч болох ахуйн бохир ус ба нефтийн бүтээгдэхүүний алдагдалаас хөрс, газрын доорх ус бохирдох, энэ бүхэн нь байгаль орчин зэрэгт сөрөг нөлөөлөх, харин энд ажлын байр болон орон нутгийн хөрөнгө оруулалт, татварын орлого нэмэгдэх, орон нутагт ядуурал буурах зэрэг эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Шууд бус нөлөөлөл: Үүнд: машин механизмын хөдөлгөөн, дуу чимээнээс зэрлэг ан амьтад үргэх дайжихад хүргэх, эдэлбэр газар, түүний орчны эвдэрсэн хөрс, дотоод тээврийн зам, ил овоолго зэргийн тоосжилтоос агаар, хөрс бохирдож уур амьсгалын бичил өөрчлөлт, болзошгүй байгалийн аюул осол (газар хөдлөл, хүчтэй салхи, гал түймэр) гарах зэрэг нөлөөлөлийг шууд бус нөлөөлөлд хамаарууллаа.

Нөлөөллийн үргэлжлэх хугацаа: Нийт нөлөөллийн ихэнх буюу 24 нь энд урт хугацаанд, 5 нь богино хугацаанд үргэлжлэхээр байна. Ил уурхайн олборлолтоос үүсэх байгаль экосистемийн өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, байгаль орчны чанарын өөрчлөлт, улс орны болон орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлэх болзошгүй нөлөөлөл зэрэг нь бараг бүгд урт хугацааны нөлөөлөл гэж үзсэн болно. Ажилчдын кемпийн ахуйн бохир усны шугам хоолойд гарах болзошгүй осол, байгалийн болон гэнэтийн осол гарах зэрэг нөлөөлөл богино хугацаанд үргэлжилнэ.

Нөлөөллийн эргэлт буцалтгүй байдал. Энд нийт болзошгүй сөрөг ба эерэг нөлөөллийг буцалтгүй ба буцаж эргэж нөлөөлөх гэж 2 хэсэгт хувааж авч үзлээ. Уурхайн олборлолтын бүхий л үйл ажиллагааны үед газрын тогтоц, орчны хөрс, ургамал, гадаргын ба газрын доорх усны урсацын ба чанарын өөрчлөлт, **“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ**
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

зэрлэг ан амьтдын амьдрах орон зайн өөрчлөлт, агаарын тоосжилт зэрэгтэй холбоотойгоор байгалийн өнгө төрх, ландшафтын хэлбэр өнгө өөрчлөгдөх нөлөөлөл нь эргэлт буцалтгүй байх болно. Харин уурхайд ажилладаг машин механизм, тоног төхөөрөмжийн болон тээвэрлэх үед гарах дуу чимээ, ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн асгарч алдагдсан тохиолдолд гарах хөрс, усны бохирдол, хог хаягдал ариутгаагүй, тухай бүрд нь устгаагүйгээс гарах сөрөг нөлөө, уурхайн осол ба байгалийн болзошгүй гамшгийн үед гарах сөрөг нөлөөллүүд нь буцаж уурхайн үйл ажиллагаа болон байгаль орчинд хүн амын амьдрах орчин, тэдний эрүүл мэндэд буцаж нөлөөлж болзошгүй байна.

Нөлөөллийн эрчим Дээрх хүснэгтээс үзэхэд уурхайн хувьд нийт нөлөөллийн 17,2% нь хүчтэй, 37.9% нь дунд зэргийн эрчимтэй, 44.9% нь бага зэргийн (сул) эрчимтэй нөлөөлөхөөр байна.

3.2. Хуримтлагдах нөлөөлөл

Ямар хүн, эсвэл ямар байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас үл хамааран тухайн нутаг дэвсгэрт хэрэгжсэн, хэрэгжиж буй, мөн ирээдүйд хэрэгжих төслийн нөлөөлөл дээр тухайн төслийн нөлөөллийг нэмэхэд тэдгээрийн нийлбэр үр дагавраас үүсэх байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг “хуримтлагдах нөлөөлөл” гэнэ.

Нарийн суухайтын бүлэг ордод 2003 оноос хойш нүүрсний олборлолт явагдсаар одоогоор тус бүсэд “Саусгоби сэндс” ХХК-аас гадна “Хүрэн толгой коал майнинг” ХХК болон “Монголын алт” ХХК, “Өсөх зоос” ХХК-иуд үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр компаниудын үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлж буй сөрөг нөлөөлөл 2003 оноос эхлэн тооцогдох юм. Овоот Толгой төслийг 2007 онд хайгуул эхлэхээс өмнө төсөл хэрэгжих явцад баригдах үйлдвэрийг барьж байгуулах, үйлдвэрлэлийн цаашдын үйл ажиллагааны явцад тухайн төслийн үйл ажиллагаа болон орон нутагт хэрэгжиж буй бусад төслийн үйл ажиллагаанаас хам нөлөөлөл үүсч, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг үр дагавар ихтэй богино болон урт хугацааны нөлөөллийг үүсгэхээр байна.

Хүснэгт 6. Төслийн үйл ажиллагаа болон бүс нутагт хэрэгжиж буй бусад төслүүдээс үүсэлтэй болзошгүй хуримтлагдах нөлөөлөл

№	Хуримтлагдах нөлөөлөл	Нөлөөллийн шалтгаан	Хамрах цар хүрээ	Үргэлжлэх хугацаа
1	Газрын доорх усны нөөц багасах	Бусад төслүүдийн усны хэрэглээ, хэрэглээний давхцал	Төслийн талбай, орон нутаг	Одоо, ирээдүйд
2	Ургамлан нөмрөгийн доройтол	Уур амьсгалын өөрчлөлт, төслийн үйл ажиллагаа	Төслийн талбай, орон нутаг	Өнгөрсөн, одоо, ирээдүйд
3	Агаарын бохирдол нэмэгдэх	Хуурайшилт, тоосжилт, нүүрсний тоосжил бусад төслүүдийн бохирдолын давхцал	Төслийн талбай, орон нутаг	Одоо, ирээдүйд
4	Хөрсний бохирдол	4 төслийн үйл ажиллагаа, зам тээвэр	Төслийн талбай, бүс нутаг	Өнгөрсөн, одоо, ирээдүйд
5	Амьтны аймаг дайжих	4 төслийн үйл ажиллагаа	Орон нутаг, төслийн талбай,	Одоо, ирээдүйд
6	Нутгийн иргэд	Байгаль орчны бохирдол, усны хомсдол	Орон нутаг	Өнгөрсөн, одоо, ирээдүйд

Хуримтлагдах нөлөөлөл, түүний үр дагаварыг бодитой тодорхойлох, эрт хугацаанд илрүүлэхийн тулд төслийн үйл ажиллагааны тодорхой үе шатуудад мониторинг байнга хийж байхыг зөвлөж байна. Тус бүс нутагт дээрхи төслүүдийн үйл ажиллагаанд байгальд ээлтэй техник технологи, менежментийг

зөрчих эсвэл өөр нэмж ямарваа нэг буюу хэд хэдэн ижил төстэй үйл ажиллагаа явуулах тохиолдолд бүс нутгийн экосистем бүрэн эвдэрч, экологийн тэнцвэргүй байдал үүсэх нь боломжтой.

Экологийн тэнцвэр алдагдах тохиолдолд нутгийн ховор, нэн ховор амьтан ургамлын аймаг устгах, хөрсний үржил шим алдагдаж ган, зудын давтагдал ойртох, ширүүн бороо хуй салхины хүч ихсэж гадаргын болон гүний усны нөөц алдрах улмаар гэнэтийн хур борооны үер буух үзэгдэл бий болох боломжтой. Иймд хуримтлагдах нөлөөллийг сайтар үнэлж, тухайн экологийн асуудал тулгарах бүр “Саусгоби сэндс” ХХК, “Хүрэн толгой коал майнинг” ХХК болон “Монголын алт” ХХК, “Өсөх зоос” ХХК-д нэгдэж, нэгдсэн байгаль орчны тулгамдсан асуудлаа хэлэлцэн, асуудлыг эрт үед нь шийдвэрлэх ёстой.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Саусгоби сэндс ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаварыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьдаг. Бид уурхайн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлж, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг бүрэн амжилттай хэрэгжүүлсээр ирсэн.

2025 оны төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавьсан.

Мөн Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг удирдлага болгосон.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж байх болно.

Бид 2025 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах гол зорилтуудыг тавьж ажиллана. Үүнд:

- Төсөл хэрэгжих нутагт байгаль орчны мэргэжлийн байгууллагаар орчны хяналт шинжилгээ, газрын доорхи усны хөндлөнгийн судалгааг мөн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. Тус ажлуудыг зэргэлдээ орших уурхайнуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- Байгаль орчинд нийлүүлэх хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах боломжтой хог хаягдлын хэмжээг өмнөх оны хэмжээ буюу 70 орчим хувьд барих
- Нефтийн бүтээгдэхүүний асгаралт урьдчилан сэргийлж, бохирдсон хөрсийг эрүүлжүүлэх, саармагжуулах үйл ажиллагааг үргэлжлүүлэнэ.
- Нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд ТЭРБУМ мод хөтөлбөрөөс манай байгууллага 15 сая мод тарих хариуцлагын гэрээнд нэгдсэн ба 2025 онд нийт 100,000 ширхэг мод тарьж ургуулахаар төлөвлөж байна.

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

- Орон нутгийн байгаль хамгаалах малчдын нөхөрлөл, Төрийн болон Төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, хамтын ажлыг үргэлжлүүлнэ.
- Цэвэрлэх байгууламжаас гарсан усыг дахин ашиглах ажлыг амжилттай хэрэгжүүлэх, үйл ажиллагааг тогтворжуулах, үргэлжлүүлнэ.
- Биет болон биет бус соёлыг хамгаалах ажлын хүрээнд нөлөөллийн сумдаас сонгон соёлын төвтэй хамтран баруун сумын иргэдийн дунд үйл ажиллагаа зохион байгуулах.

4.1. Эрх зүйн үндэслэл

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавьсан.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 31.4 дэх заалт болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.6, 9.7 дахь заалт, 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүнг удирдлага болгон ажиллана.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлс хийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг хангаж, явцад нь хяналт тавин ажиллах болно.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулийн дээрх шаардлагын дагуу Овоот Толгой уурхайн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг жил бүр шинэчилэн боловсруулж хэрэгжилтийг хангасаар ирсэн.

Овоот Толгой уурхайн БОННУ-ний нэмэлт тодотголын тайланд тусгагдсан байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөхдөө, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын хүрээнд гарсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” боловсруулах зөвлөмжийн дагуу төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт хуваан агаар, гадаргын ба газрын доорхи ус, хөрсөн бүрхэвч, газрын хэвлий, ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн төлөвлөсөн.

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

Саусгоби сэнс ХХК 2025 онд байгаль хамгаалах үйл ажиллагааны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 8 ажил төлөвлөсөн (Хүснэгт 8-аас харна уу)

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах ажил

№	Байгаль орчны бүрэлдэхүүн	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах ажил	Гарах үр дүн	Төсөв	Хариуцах эзэн	Аргачлал, стандарт
1	Агаар	Хөдөлгөөнт тоног төхөөрөмжөөс тоосжилт үүсэх (хөрс хуулалт, тэсэлгээ, нүүрс олборлох, хаягдал хөрсийг овоолох, асгах, тээвэрлэх)	Замын усалгаа хийж тоосыг бууруулах, сайн туршлага нэвтрүүлэх, хурдны хязгаар барих	Тоосжилтыг дарна	Дотоод Үйл ажиллагаа	ХАБЭА,Б ООНХ, Олборлолын хэлтэс	МУ-ын болон Овоот Толгой уурхайн замын хөдөлгөөний дүрэм
2	Хөрс	Тос тосолгоо, түлш хөрсөнд асгарч хөрсийг бохирдуулах	Асгаралт болсон тохиолдолд бохирдсон хөрсийг цэвэрлэх саармагжуулах	Асгаралтай тэмцэх иж бүрдэл ашиглах, бохир хөрсийг бохирдсон хөрс хураах, эрүүлжүүлэх талбайд хураасан байна.	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА,Б ООНХ, Олборлол, Засвар, Хангамжийн хэлтэс	Гидрокарбон асгаралт тэмцэх журам
3		Хөрс хуулагдах, түүний физик химийн шинж чанарт өөрчлөлт орох Хөрсний биологийн цикл алдагдах	Эрүүл газар хөндөх тохиолдолд заавал шимт хөрсийг хуулах	Шимт хөрсийг стандартын дагуу хуулж хадгална	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА,Б ООНХ, ОХ, Төлөвлөлтийн хэлтэс	Овоот Толгой уурхайн газар хөндөх журам Үржил шимт хөрсийг хуулах хадгалах ерөнхий шаардлага
4	Гадаргын болон гүний ус	Усны хэрэглээ ихсэх болон ус шавхалтын үйл ажиллагааны улмаас төслийн талбай, түүний орчмын газрын доорх усны түвшин буурах	Уурхайн усны хэрэглээг оновчтой болгох зорилгоор мэргэжлийн зөвлөх авч хамтран ажиллах ажлыг зохион байгуулах,	Ус ашиглалттай холбоотой сургалт, арга зүйн зөвлөмж өгсөн байна, тайлан гарсан байна.	20,000.0	БООНХХэлтэс	Ажилчдын экологийн боловсролын дээшлүүлэх сургалтын хөтөлбөр
5		Химийн бодис материал шатах тослох материалын алдалт, асгаралтаас усны чанарт нөлөөлөх, бохирдох	Асгаралт болсон торхиодол цаг алдалгүй арга хэмжээ авах Химийн бодис болон шатах, тослох материалыг хадгалалт ашиглалтанд тогтмол хяналт тавих.	Асгаралт болсон тохиолдол арга хэмжээг яаралтай авсан байна. Шинжлэгээний хариу авсан байх	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭА,Б ООНХ, Засвар, ОХ Агуулах	Овоот Толгой уурхайн гидрокарбон асгаралт

№	Байгаль орчны бүрэлдэх үүн	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах ажил	Гарах үр дүн	Төсөв	Хариуцах эзэн	Аргачлал, стандарт
6	Ургамал	Тоосны дэгдэлт нь ургамлын навчны амсрыг хаах, ургах чадварыг алдагдуулах	Тоосыг эх үүсвэр дээр нь дарах арга хэмжээг тогтмол авна	Хуурай баяжуулах үйлдвэрийн гаралтын хэсэгт тоос баригч хийнэ	40,000.0	ХАБЭА,Б ООНХ, Олборлолт	Овоот Толгой уурхайн тоос дарах журам
7	Амьтан	Хууль бус анг таслан зогсоох	Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хамтарсан багийг санхүүжүүлэх хамтран ажиллах	Хамтарсан багийн тайлан, мэдээ гарсан байна. Хамтарсан багийн	5,000.0	БООНХ хэлтэс	Амьтны тухай хууль
8	Газрын хэвлий	Ил уурхай (ухагдсан нүх)	Зөвшөөрөгдсөн талбайд зөвшөөрлийн дагуу олборлолт явуулах, гадаад овоолго үүсгэх үйл ажиллагаа явуулах	Зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явагдах	Дотоод үйл ажиллагаа	Бүх хэлтэс	Газрын тухай ашигт малтмалын тухай хууль
НИЙТ ДҮН					65,000.0		

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Манай компани 2009 оноос техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг эхлэсэн бөгөөд сүүлийн 12 жилийн хугацаанд уурхайд 147.84 га талбайд техникийн, 55.16 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж орон нутаг, улсын комисст хүлээлгэн өгсөн байна 2021 онд Сэврэй суманд эвдэрч эзэнгүй орхигдсон 15 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 2024 онд Номгон сумын Элстэйд гар аргаар алт олборлон эвдэрч орхигдсон 10 га газарт техникийн нөхөн сэргээлтийг тус тус хийж Өмнөговь аймгийн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Сэврэй, Номгон сумдын тамгын газарт хүлээлгэн өгсөн.

2025 онд уурхайн бүсэд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх талбай төлөвлөгдөөгүй тул Өмнөговь аймгийн БОАЖГ-аас чиглэл авч техникийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөж байна. Ерөнхийлөгчийн санаачилсан ТЭРБУМ мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг бие даасан хөтөлбөр болгож төсөв зохион байгуулалтыг тусад нь авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. ТЭРБУМ мод хүрээнд зарчуулагдах төсөв нь БОМТ-ний нийт төсөв тусгагдахгүй ба тусдаа бие даасан төсөл хөтөлбөрөөр хэрэгжих болно.

Үүнд:

- Өмнөговь аймгийн Гурвантэс, Сэврэй сумын нутагт нийт 40.000 ш Заг мод,
- Шинэ дагуул хот болох Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт 55.000 ширхэг навчит болон шилмүүст мод
- Овоот толгой уурхайн кемп, кемпийн өргөтгөлийн ногоон байгууламжид 5000 ш Хайлаас мод тарьж нэмэгдүүлнэ.

Хүснэгт 9.Нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах зардлын задаргаа

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал. Мян.төг	Нийт зардал. Мян.төг	Хэрэг жүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	Эвдэрч орхигдсон талбайд техникийн нөхөн сэргээлт хийх Өмнөговь аймгийн БОАЖ-ын газраас чиглэл талбай зааж өгөх	Орон нутгийн аж ахуй нэгжтэй хамтран гэрээ байгуулж эвдэрсэн талбайг нөхөн сэргээх	Га	10	13,000.0	130,000.0	2025 оны 4-11 сар	БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаал
НИЙТ ТӨСӨВ						130,000.0		

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сүүлийн жилүүдэд Монгол улсад уул уурхай, түүнийг дагасан дэд бүтэц, бусад бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүд эрчимтэй хөгжихийн хирээр биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөлөл нэмэгдсээр байна.

Нөлөөллийг бууруулах дарааллыг зохистой хэрэгжүүлэх, олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас холбогдох эрх зүйн орчныг бий болгон ажиллаж аж ахуйн нэгж байгууллагууд түүнийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Саусгоби сэндс ХХК нь Овоот толгой уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байхаар төлөвлөн хамгааллын ажлыг шат дараатай хэрэгжүүлж байна. Үүний

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

нэг нь биологийн олон янз байдлын амьдрах орчинг тэтгэх, тэдгээрийн үйлчилгээг дэмжих, судалгаа шинжилгээний ажилд үндэслэн хамгааллын менежментийн ажлыг зохион байгуулах ажил юм. Төслийн үйл ажиллагаа явуулж буй цөл, цөлөрхөг хээрийн бүс нутаг нь эрс тэс уур амьсгалтай, эмзэг экосистемд тооцогддог.


Экосистемийг бүрдүүлж буй биологийн олон янз байдлын зүйл дотор олон улс болон бүс нутгийн хэмжээнд ховор, ховордож болзошгүй, мөн популяцийн төлөв байдлын мэдээлэл дутмаг амьтан, ургамал олон бөгөөд тэдгээрийг хамгаалах, сөрөг нөлөөлөлд өртүүлэхгүй байлгах нь компаний байгаль орчны бодлогын нэг хэсэг юм.

Бид 2015 онд Овоот толгой уурхайн орчимд биологийн олон янз байдлын нарийвчилсан судалгаа хийж, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах хэд хэдэн газрыг судалгааны үндсэн дээр тодорхойлон ажиллалаа.

Дээрх судалгааны үр дүнд Дүйцүүлэн хамгаалах газраар доорх газруудыг санал болгов. Үүнд:

Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалахаар санал болгож буй газар

Д/д	Санал болгосон газрын нэр	Талбайн хэмжээ
1	Хуршуут, Наранбулаг, Дэлийн ус, Хөвдийн булаг	75023.88 га
2	Тост Тосон бумбын нуруу	103077.36 га
3	Сухантын булаг	8526 га



Зураг 17. Дүйцүүлэн хамгаалахаар санал болгож буй газар нутаг

Бид судалгааны ажлын үр дүнд санал болгосон газруудаас сум орон нутагт танилцуулж дүйцүүлэн хамгаалах ажлыг 2016-2024 онуудад Тост Тосон бумбын нуруунд гүйцэтгэсэн.

Тус газрыг сонгосон гол үндэслэл нь байршил нутгийн хувьд том хэмжээтэй, нэн ховор, ховор зүйл болох цоохор ирвэсийг хамгаалах, мөн идэш тэжээлийн холбоотой аргаль хонь, янгир ямаа зэрэг дэлхийд ховордсон зүйлүүдийг хамгаалах, тогтвортой өсөх нөхцлийг бүрдүүлэх, тархац нутаг, амьдрах орчныг хамгаалах явдал юм. Ховор ба ховордсон амьтдаас гадна харьцангуй өргөн тархалттай хуурай болон цөлжүү хээрийн амьтдын тодорхой тархац нутаг, амьдрах орчныг хамгаалахад чухал ач холбогдолтой.

2025 онд Биологийн олон янз байдлыг Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Тост, Тосон-Бумбын нурууны байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаатай хамтран тодорхой нэг ажлыг санхүүжүүлэх, хамтран ажиллахаар төлөвлөв. Тус ажилдаа Өмнөговь аймгийн БОАЖГ-аас гаргасан саналыг үндэслэн хамтран ажиллана.

Дүйцүүлэн хамгаалах ажилд манай компанийн зүгээс зарцуулагдах зардлын тоймыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар баталсан журмын холбогдох загварт туссан хүснэгтийн дагуу тусгав.

Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах ажлын зардал

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал. Мян/төг	Нийт зардал. Мян.төг	Хэрэг жүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	Дүйцүүлэн хамгаалах ажлыг жишиг байдлаар гүйцэтгэж бусад уурхайг манлайлах	ТТБумбын нурууны байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаатай хамтран тодорхой нэг ажлыг санхүүжүүлэх	Тост, Тосон-Бумбын нурууны байгалийн нөөц газарт байгаль хамгааллын ажил хийгдсэн байх	-	40,000.0	40,000.0	2025 оны 8-12 сар	БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн тушаал

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Овоот Толгой уурхайн хувьд төслийн талбайд газар эзэмшигч, нутагладаг малчдаас бодит нүүлгэн суурьшуулалтанд хамруулсан бөгөөд цаашид газар ашиглалтыг нэмэгдүүлэхгүй байх, зайлшгүй тохиолдлоос бусад үед бодит нүүлгэн суурьшуулалтаас татгалзах бөгөөд 2025 онд нүүлгэн суурьшуулалтанд хамрагдах өрх байхгүй. Нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан өрхүүдийн амьжиргааг дэмжих, өрхийн орлого нэмэгдүүлэх зорилгоор ажлын байраар хангах, цалинжуулах, гэрээт ажил гүйцэтгүүлэх.

Хүснэгт 12. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал. төг	Нийт зардал. төг	Хэрэг жүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	Нөлөөлөлд өртсөн өрхийн гишүүд	цалинжуулах	Байнгын ажлын байр-3	12 сар	3,900.0	46,800.0	2025 он	АМТ хуулийн 42.1 дэх хэсэг Хамтын ажиллагааны гэрээ
2	Нөлөөлөлд өртсөн өрхийн гишүүд	Гэрээгээр ажил гүйцэтгэх	Гэрээт ажил	Улирал тутам	1,200.0	4,800.0	2025 он	АМТ хуулийн 42.1 дэх хэсэг Хамтын ажиллагааны гэрээ
Нийт төсөв						51,600.0		

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Бид 2025 онд биет бус өвийн хүрээнд нөлөөллийн сумдын соёлын төвтэй хамтран 1-ээс доошгүй үйл ажиллагаа зохион байгуулах.

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

Хүснэгт 13. Соёлын өвийг хамгаалах хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Биет бус өвийг хамгаалал	Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх	Цагаан сарын тавгийн идээ	40,000.0	40,000.0	2025 оны 1-р улирал	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
	Сумдын соёлын төвтэй хамтран ажиллах	Баруун сумын иргэд	5,000.0	5,000.0	2025 оны 3-р улирал	
НИЙТ ДҮН				45,000.0	-	

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бид Овоот Толгой уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа химийн бодис материалуудын худалдан авалт, тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт болон устгал зэргийг Монгол улсын зохих стандарт, журамд нийцүүлэн боловсруулсан компанийн дотоод журмын дагуу гүйцэтгэдэг.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс, Байгаль орчин, орон нутгийн харилцааны хэлтэс уурхайд ашиглагдаж буй химийн бодис материалын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт түүний хаягдал болон сав баглаа боодлын устгалд хяналт тавьж, аливаа үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллана.

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Овоот Толгой уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа химийн бодис материалуудын худалдан авалт, тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт болон устгал аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Тусгай зөвшөөрөлд заагдсан бүх химийн бодисууд	ҮА зардалд	-	Өдөр бүр, тогтмол ХАБ болон томилсон этгээд	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1 Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Нийт ажиллах хугацаанд Уурхайн бүх ажилчдад	Дотоод үйл ажиллагаа	-	2025	
	Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах,	Төслийн хүрээнд	Галын хөөс 3 тн х 11.0 = 33.0 Бусад -6.1	39 100.0	2025	
	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулаж батлуулах	Үйл ажиллагааны турш	ҮА зардалд	-	2025	
Хүний эрүүл мэндэд нөлөөлөл үүсэх	Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангах	Үйл ажиллагааны турш	400 хүн *169.0	67600.0	2025	
Нийт дүн				106,700.0		

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хог хаягдлыг төрөл тус бүрээр ангилан ялгах, түр хадгалах, зориулалтын цэгт тээвэрлэх	Үйл ажиллагааны турш	12,000.0 x 12 сар	144, 000.0	Сар бүр	Гурвантэс сумын ЗДТГ-ын шийдвэр
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, тэсрэх материалын агуулах, ШТС зогсоол зэрэг газарт байрлуулах	Үйл ажиллагааны турш	ҮА зардалд	-	2025	
	Хог хаягдал үйлдвэрлэсний төлбөр	Жилд	200,0	2,400.0		

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Экспортын тээврийн машины зогсоол, хяналт зохион байгуулалтын талбайн хог цэвэрлэгээ, тээвэрлэлт	Үйл ажиллагааны турш	6,000.0 x 12	72,000.0	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Хаягдал хаягдлын төлбөр ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Үйл ажиллагааны турш	Хэрэглээний хэмжээгээр	-	2025	
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш	ҮАЗардалд	-	2025	
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Уурхайн тосгоны цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, хэвийн үйл ажиллагааг хангах	Ажилчдын сууринд	ҮАЗардалд	-	2025	Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,
Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Агаар бохирдлын төлбөрийг техник тус бүрт төлөх	-	ҮАЗардалд тусгасан	2025	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
НИЙТ ДҮН				218,400.0		

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Бид Овоот Толгой нүүрсний уурхайн төслийг хэрэгжүүлэх явцад БОННУ-ий тайлан, БОХТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг шалгах, үнэлэх ажлын хэсэг 2015 оны дүгнэлтэд “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”-ийг зэргэлдээ орших уурхайнууд хамтран зохион байгуулахыг тусгасан байдаг.

Иймд Нарийн сухайтын нүүрсний бүлэг ордод орших уурхайнууд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх шаардлага бий болж 2016 оноос Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг 8-дахь жилдээ хамтран хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн 2025 онд уурхайнууд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх болно.

Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын задргаа


№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналты цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Агаар	Өмнөговь аймаг Гурвантэс сум Бага овоо 5-р баг Нарийн Сухайтын бүлэг орд Саусгоби сэнс ХХК талбай	Жилд нэг удаа 2025.11 сар	12 цэгээс	160.0	2,880.0	Ажилчидын цалин, хээрийн судалгаа, тайлан боловсруулах зардал ороогүй болно	MNS 3384:1984 MNS 4585:2016
2	Хөрс			12 цэгээс	160.0	3,040.0		MNS 3298:1990 MNS 3310:1991
3	Гадаргын ус			5 цэгээс	189.6	948.0		MNS ISO 5667-6-2001 MNS ISO 5667-10-2001 MNS 4586:1998
4	Газрын доорх ус			3 цэгээс	194.0	1,552.0		MNS 900:2018
5	Ургамлан бүрхэвч			11 цэгээс	120.0	1,800.0		Друде (1913)-гийн нүдэн баримжааны арга. Ургамлын зүйлийг Грубов (1982)-ын таних бичиг-ээр тодорхойлно. Ургамлан нөмрөгийн талхагдлын зэргийг Гунин, Востокова 7(1989) нарын аргаар тус тус тодорхойлох
6	Амьтны аймаг			9 цэгээс	110.0	1,980.0		Нүдээр ажиглагдсан амьтдыг бүртгэж тэмдэглэхээс гадна ул мөрөөр(баас, мөр) зарим амьтдыг бүртгэв. Нэг цэгээс нөгөө цэг хүртэл замналаар явж тааралдсан амьтдыг бүртгэн байршлыг тэмдэглэсэн.
7	НИЙТ ЗАРДАЛ					12,200.0		-

13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Саусгоби сэндс компани нь Монгол улсын байгаль орчинтой холбоотой хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байлгах, нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, дүйцүүлэх хамгаалах, төсөл хэрэгжих орчинд бий болох болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг тогтмол хянаж, илрүүлэх, хариу арга хэмжээ авах, орон нутгийн иргэдийн оролцоотой байгаль орчныг хамгаалж, уг үйл ажиллагаанд манлайлагч байхыг зорьж ажилладаг болно.

Бид 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд доорх удирдлага зохион байгуулалтын бүтэцтэйгээр ажиллах болно.

Үүнд



Бид Овоот Толгой уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг тогтмол хянах, илрүүлэх, түүний дагуу хариу арга хэмжээ авах мөн нутгийн иргэдийн оролцоотой байгаль орчныг хамгаалах, хамтран ажиллах зорилт тавьсан.

Бид өнгөрсөн оны БОМТ хэрэгжилт түүнээс гарсан дүгнэлт зөвлөмж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн төлөвлөсөн. Энэ жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт **728.55** сая төгрөг төсөвлөөд байна.

“ОВООТ ТОЛГОЙ” УУРХАЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025				
			4-6 сар	6-9 сар	9-12сар		
1	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулах	Дотоод Ү.А	+			БООНХ-ны хэлтэс	
2	Өвөлжилт хүндэрсэн нөхцөлд Гурвантэс сумын БОХУБайцаагч, Байгаль хамгаалагч нартай хамтран Биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2,200.0	+			БООНХ-ны хэлтэс	
3	Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдийг 3-аас доошгүй удаа сургуулийн хүүхдүүд болон иргэдийн экологийн боловсролыг дэмжих үүднээс зохион байгуулах	10,000.0	+	+	+	БООНХ-ны хэлтэс	
4	Ахуйн хог хаягдлыг хэмжээг бага байлгах үүднээс шатаах зуух ашиглалтанд оруулах, агаарт хорт утаа дэгдэхгүй нөхцөл бүрдүүлэх	Дотоод Ү.А	+	+	+	БООНХ-ны хэлтэс	
5	Ус ашиглах дүгнэлт гаргуулах, Ус ашиглах гэрээг холбогдох төрийн байгууллагатай хийх	Дотоод Ү.А	+			БООНХ-ны хэлтэс	
6	Уурхайд ашиглагдаж буй бүх усны эх үүсвэрүүдээс дээж авч шинжилгээнд явуулах, чанарт хяналт тавина	Дотоод Ү.А		+		БООНХ-ны хэлтэс	
7	Булаг шандын эхийг хамгаалах ажлыг ШУ-ны үндэслэлтэй мэргэжлийн байгууллагаар зураг гаргуулан гүйцэтгүүлэх	35.450.0	+	+	+	БООНХ-ны хэлтэс	
8	Байгаль орчны үнэлгээ хийлгэх ажлыг олон нийтэд танилцуулах тэдний саналыг тусгах ажлыг тухай бүр зохион байгуулах	5,000.0	+		+		
9	Нийт ажилчдад уурхайн хог хаягдлын талаар сургалт зохион байгуулах	Дотоод Ү.А	+			БООНХ-ны хэлтэс	
10	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжилтйн жилийн тайлан мэдээ боловсруулах, нийтэд тайлагнах	Дотоод Ү.А			+	БООНХ-ны хэлтэс	
НИЙТ ДҮН		52,650.0					

14. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ
Төсөл хэрэгжүүлэгч “Саусгоби сэндс” ХХК жил бүр БОМТ -ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн нийтийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг жил тутамд хийнэ.

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал	Хариуцан зохион байгуулах ажилтан	Зохион байгуулах газар
Сум, багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	7,000.0	БООНХ-ны хэлтэс	Бага Овоо багийн төвд
БОАЖЯ	Системээр тайлан илгээх	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12 -р сар	Дотоод Ү.А	БООНХ-ны хэлтэс	Интернэт орчин
НИЙТ ДҮН				7,000.0	-	

ХАВСРАЛТ